



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 594

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалт, Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2023 оны 14/03, 15/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн өмчөөс шилжүүлсэн 4 нэрийн, нийт 69,800,000.00 (жаран есөн сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 55,513,800.00 (тавин таван сая таван зуун арван гурван мянга найман зуун) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирагч, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цогтсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны 11 дугаар сарын 23-ны өдрийн
21.1 дугаар тогтоолын хавсралт

УВС АЙМГИЙН ӨМЧӨӨС ШИЛЖҮҮЛСЭН, ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар	Үй.ор/Аш.ор огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Эзэмшигч байгууллагы н нэр	Шилжүүлэн авч, бүртгэх байгууллагын нэр
1	Форд Транзит, 73-79 УВА	2006/2018	ш	1	25,000,000.00	19,444,400.00	5,555,600.00	Аймгийн ЗДТГ	Увс аймгийн Гаалийн газар
2	УАЗ-31519, 00-13УВХ	2016/2019	ш	1	25,000,000.00	18,750,000.00	6,250,000.00	Сатил сумын ЗДТГ	Увс аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс
3	Тоёота, приус 20, 00- 32 УВХ	2008/2017	ш	1	9,800,000.00	8,847,200.00	952,800.00	Улаангом сумын ЗДТГ	Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар
4	Соната-7, 00-21 УВА	2011/2017	ш	1	10,000,000.00	8,472,200.00	1,527,800.00	Аймгийн ЗДТГ	Хилийн боомтын захиргаа
Нийт дүн					69,800,000.00	55,513,800.00	14,286,200.00		
					(жаран есөн сая найман зуун мянган)	(тавин таван сая таван зуун арван гурван мянга найман зуун)	(арван дөрвөн сая хоёр зуун наян зургаан мянга хоёр зуун)		